



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 06 сарын 23 өдөр

Дугаар А/438

Булган сум

“Эрх зүйн зөвлөх үйлчилгээ” арга хэмжээг зохион байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.2, 28.1.3, 28.1.4 дэх заалт, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны хуралдааны VII/38 дугаар тогтоол, Аймгийн Засаг даргын 2025 оны А/360 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн хэмжээнд төрийн албан хаагч, иргэнд гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, шинээр хэрэгжиж буй хуулиудаар сургалт, мэдээлэл, эрх зүйн туслалцаа, зөвлөгөөг хүргэх зорилгоор “Эрх зүйн зөвлөх үйлчилгээ” арга хэмжээг 2025 оны 06 дугаар сарын 25-ны өдрөөс эхлэн 2025 оны 07 дугаар сарын 07-ны өдөр хүртэл зохион байгуулсугай.

2. “Эрх зүйн зөвлөх үйлчилгээ” арга хэмжээг зохион байгуулахад шаардлагатай 2,778,000 (хоёр сая долоон зуун далан найман мянга) төгрөгийг “Амар тайван Булган” хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардлаас санхүүжүүлэхийг Аймгийн Засаг даргын тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Д.Наранбаяр)-д зөвшөөрсүгэй.

3. “Эрх зүйн зөвлөх үйлчилгээ” арга хэмжээг удирдлага зохион байгуулалтаар ханган үр дүнтэй, хүртээмжтэй хэлбэрээр чанартай гүйцэтгэж, ажиллахыг Аймгийн Засаг даргын тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтэс (Б.Одхүү)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Д.ПҮРЭВ-ОЧИР